



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/188/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261740 Цахим хаяг: tserenkhuu_audit@yahoo.com
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Б энд С аудит ХХК
Захирал: Д.Дашхорлоо
Утас: 70114810 Цахим хаяг: audit_bc@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Төлбөрийн акт	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16
6. Төлбөрийн акт	17
7. Албан шаардлага	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/25

танай _____-ны № _____-т

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ
БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.БААСАНДОРЖ
ТАНАА АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>154,058,260.75</u>	<u>261,465,537.39</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	169,697.65	159,786.53
335	Бусад авлага	169,697.65	159,786.53
3351	Байгууллагаас авах авлага	-	159,786.53
3352	Хувь хүмүүсээс авах авлага	169,697.65	-
35	БАРАА МАТЕРИАЛ	153,888,563.10	261,305,750.86
351	Түүхий эд материал	6,267,000.00	6,267,000.00
35110	Тусгай зориулалттай материал	6,267,000.00	6,267,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	110,813,656.31	170,763,050.06
354	Хангамжийн материал	36,807,906.79	84,275,700.80
35410	Бичиг хэргийн материал	8,622,840.00	16,016,905.00
35420	Аж ахуйн материал	25,295,049.29	66,258,046.04
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	890,017.50	749.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,693,299,002.43</u>	<u>1,336,603,852.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,693,299,002.43	1,336,603,852.38
392	Биет хөрөнгө	1,650,303,403.43	1,293,608,253.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,136,328.00	9,136,328.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,699,974.16)	(7,258,305.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	396,900,000.00	410,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(220,216,666.64)	(274,523,611.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,735,085,934.57	2,685,418,604.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,421,768,115.53)	(1,672,651,780.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	287,599,629.98	304,299,629.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(129,733,732.79)	(161,212,612.27)
393	Биет бус хөрөнгө	42,995,599.00	42,995,599.00
39301	Программ хангамж	43,445,599.00	43,445,599.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,847,357,263.18</u>	<u>1,598,069,389.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>160,423.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	160,423.00	-
413	Өглөг	160,423.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	70,000.00	-
4136	Бусад өглөг	90,423.00	-
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	90,423.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,847,196,840.18</u>	<u>1,598,069,389.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	964,525,286.31	964,525,286.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	964,525,286.31	964,525,286.31
51101	Өмч: - төрийн	964,525,286.31	964,525,286.31
512	Хуримтлагдсан үр дүн	879,012,846.37	629,885,395.96
51210	Өмнөх үеийн үр дүн	879,012,846.37	879,173,269.37
51220	Тайлант үеийн үр дүн		(249,287,873.41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,658,707.50	3,658,707.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,847,357,263.18</u>	<u>1,598,069,389.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,233,880,590.50	4,220,828,590.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	399,004,590.50	99,956,790.00
120	Нийтлэг татварын бус орлого	399,004,590.50	99,956,790.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	399,004,590.50	99,816,790.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	399,004,590.50	99,816,790.00
120009	Бусад орлого-120017		140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,834,876,000.00	4,120,871,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,834,876,000.00	4,120,871,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,809,876,000.00	4,089,671,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	25,000,000.00	31,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,241,291,225.64	4,470,077,248.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,241,291,225.64	4,470,077,248.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,161,451,591.10	4,468,040,881.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,940,236,843.95	3,257,766,728.54
210101	Үндсэн цалин	2,552,290,974.54	1,639,892,529.77
210102	Нэмэгдэл	387,945,869.41	990,937,899.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт		249,936,300.00
210104	Урамшуулал		376,999,999.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	403,572,799.42	429,040,827.64
210201	Тэтгэврийн даатгал	285,673,337.71	336,940,834.39
210202	Тэтгэмжийн даатгал	29,489,716.20	20,987,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,591,772.85	13,397,093.25
210204	Ажилгүйдлийн даатгал	5,892,542.95	5,246,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,925,429.71	52,468,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,037,000.00	81,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	11,850,000.00
210304	Байрны түрээс	74,037,000.00	69,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,450,402.01	87,259,379.70
210401	Бичиг хэрэг	32,772,240.00	12,441,162.00
210402	Тээвэр, шатахуун	33,051,300.00	63,516,889.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,501,069.46	2,014,513.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	804,212.55	888,076.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321,580.00	8,398,737.50
2105	Нормативт зардал	538,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	538,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,943,452.16	79,598,021.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,331,600.00	7,814,935.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,006,368.16	51,783,086.76
210604	Урсгал засвар	54,605,484.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,449,973.53	69,074,883.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,599,580.00	49,922,755.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,547,792.00	7,169,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,854,330.00	409,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	121,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	305,000.00	3,145,416.56
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,488,271.53	5,806,912.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,223,120.03	463,701,039.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	11,749,021.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,480,000.00	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	470,743,120.03	451,902,018.05
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,839,634.54	2,036,367.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,839,634.54	2,036,367.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,839,634.54	2,036,367.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(7,410,635.14)	(249,248,658.41)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	953,170.00	39,215.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	953,170.00	39,215.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(953,170.00)	(39,215.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,363,805.14)	(249,287,873.41)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	887,376,651.51	1,855,560,645.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	887,376,651.51	1,855,560,645.32
4	Тайлант үеийн үр дүн			-8,363,805.14	-8,363,805.14
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	879,012,846.37	1,847,196,840.18
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			160,423.00	160,423.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	879,173,269.37	1,847,357,263.18
8	Тайлант үеийн үр дүн			-249,287,873.41	-249,287,873.41
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	629,885,395.96	1,598,069,389.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>3,834,946,000.00</u>	<u>4,121,011,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	140,000.00
120009	Бусад орлого	70,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,834,876,000.00	4,120,871,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,834,876,000.00	4,120,871,800.00
131001	Үйл ажиллагааны санхүүжилт	3,809,876,000.00	4,089,671,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	25,000,000.00	31,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,778,633,000.00</u>	<u>4,070,501,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,778,633,000.00	4,070,501,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,698,793,365.46	4,068,464,833.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,935,982,570.58	3,215,980,699.14
210101	Үндсэн цалин	1,506,108,305.89	1,598,106,500.37
210102	Нэмэгдэл	990,937,970.15	990,937,899.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	107,936,294.54	249,936,300.00
210104	Урамшуулал	331,000,000.00	376,999,999.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	403,572,799.42	468,112,334.39
210201	Тэтгэврийн даатгал	296,254,900.00	336,940,834.39
210202	Тэтгэмжийн даатгал	26,829,499.51	20,987,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,463,600.00	52,468,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,365,899.98	5,246,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	53,658,899.93	52,468,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,037,000.00	81,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	11,725,000.00	11,850,000.00
210304	Байрны түрээс	75,312,000.00	69,750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,916,045.46	98,389,600.00
210401	Бичиг хэрэг	8,262,410.00	13,264,900.00
210402	Тээвэр, шатахуун	32,002,400.00	60,602,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,501,069.46	1,947,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	402,900.00	402,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,747,266.00	22,172,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,017,080.00	76,632,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,837,580.00	24,156,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,477,500.00	32,475,800.00
210604	Урсгал засвар	66,702,000.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,269,470.00	112,679,499.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,217,198.00	87,942,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,172,722.00	7,169,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,400.00	409,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,854,450.00	4,857,399.56
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,140,700.00	9,679,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,998,400.00	15,070,099.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	15,020,099.91

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,998,400.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,839,634.54	2,036,367.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,839,634.54	2,036,367.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,839,634.54	2,036,367.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>56,313,000.00</u>	<u>50,510,600.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,313,000.00	50,510,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,313,000.00	50,510,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,313,000.00	50,510,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,313,000.00	50,510,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(56,313,000.00)</u>	<u>(50,510,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,089,671,800.00	4,087,775,433.00	1,896,367.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	4,089,671,800.00	4,087,775,433.00	1,896,367.00	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,089,671,800.00	4,087,775,433.00	1,896,367.00	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,217,629,200.00	3,215,980,699.10	1,648,500.90	99.9
Үндсэн цалин	1,599,755,000.00	1,598,106,500.40	1,648,499.60	99.9
Нэмэгдэл	990,937,900.00	990,937,899.20	0.80	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	249,936,300.00	249,936,300.00	0.00	100.0
Урамшуулал	377,000,000.00	376,999,999.60	0.40	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	468,190,800.00	468,112,334.40	78,465.60	100.0
Тэтгэврийн даатгал	337,019,300.00	336,940,834.40	78,465.60	100.0
Тэтгэмжийн даатгал	20,987,400.00	20,987,400.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	52,468,600.00	52,468,600.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	5,246,900.00	5,246,900.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	52,468,600.00	52,468,600.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,600,000.00	81,600,000.00	0.00	100.0
Гэрэл, цахилгаан	11,850,000.00	11,850,000.00	0.00	100.0
Байрны түрээс	69,750,000.00	69,750,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	116,769,500.00	116,749,500.00	20,000.00	100.0
Бичиг хэрэг	13,264,900.00	13,264,900.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	60,602,400.00	60,602,400.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,000.00	1,947,000.00	0.00	100.0
Ном, хэвлэл	0.00	0.00	0.00	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	402,900.00	402,900.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,552,300.00	40,532,300.00	20,000.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	88,815,100.00	88,813,400.00	1,700.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	36,337,600.00	36,337,600.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,477,500.00	32,475,800.00	1,700.00	100.0
Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,617,200.00	98,469,499.60	147,700.40	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,642,400.00	74,642,400.00	0.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,500,000.00	100,000.00	96.2
Даатгалын үйлчилгээ	7,169,100.00	7,169,100.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	409,700.00	409,700.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	168,700.00	121,000.00	47,700.00	71.7

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,947,400.00	3,947,399.60	0.40	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,679,900.00	9,679,900.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	18,050,000.00	18,049,999.90	0.10	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	17,999,999.90	0.10	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	50,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,089,671,800.00	4,087,775,433.00	1,896,367.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,089,671,800.00	4,087,635,433.00	2,036,367.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	4,089,671,800.00	4,087,635,433.00	2,036,367.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	140,000.00	-140,000.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	140,000.00	-140,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	139	166	-27	119.4
Удирдах ажилтан	8	7	1	87.5
Гүйцэтгэх ажилтан	119	138	-19	116.0
Үйлчлэх ажилтан	12	21	-9	175.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,200,000.0
УРСГАЛ ЗАРДАЛ		31,200,000.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,200,000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,200,000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		15,000,000.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		16,200,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,200,000.0
ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		31,200,000.0
Улсын төсвөөс санхүүжих		31,200,000.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Заяажаргал, аудитор С.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Ц.Жамъянхорол хэрэгжүүлсэн.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайланг Б энд С аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар нь Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилготой, гаалийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг гаалийн бодлого, тэргүүлэх чиглэл, стратегитай уялдуулан хөгжүүлж, өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,241,291.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 63,619.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 249,288.6 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	169.7	159.8	(9.9)
Бараа материал	153,888.5	261,305.7	107,417.1
Үндсэн хөрөнгө	1,693,299.0	1,336,603.9	(356,695.1)
Нийт хөрөнгө	1,847,357.2	1,598,069.3	(249,288.6)
Өр төлбөр	160.4	-	(160.4)
Засгийн газрын хувь оролцоо	964,525.3	964,525.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	879,012.8	629,885.3	(249,127.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,658.7	3,658.7	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,847,357.2	1,598,069.3	(249,288.6)

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 261,305.7 мянган төгрөг болж өмнөх оноос 107,417.1 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын хомсдол, үнийн өсөлтөөс зайлсхийх үүднээс бичиг хэргийн материал, принтерийн хор болон ажлын байрны нүүлгэлт, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бараа материал бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,452,700.2 мянган төгрөг болж өмнөх оноос 19,467.3 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын албан бичгийн дагуу 174,174.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, урсгал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 50,510.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 104,196.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,159,876.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 929,795.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4,089,671.8 мянган төгрөгөөр баталсан нь Хөшгийн хөндийн шинэ нисэх буудал ашиглалтад орсонтой холбоотой зардал нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 төсөл хөтөлбөрийн 42 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,089,671.8 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 4,087,635.4 мянган төгрөг зарцуулж 2,036.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 31,200.0 мянган төгрөгийн орлого орсон. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 15,000.0 мянга, мэдээлэл технологийн үйлчилгээнд 16,200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон онцолсон асуудал байхгүй учир санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгад тусгагдаагүй асуудал байхгүй болно.

Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн Б/116 тоот тушаалаар байгууллагын даргыг түр орлон гүйцэтгэгчээр, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн Б/188 тоот тушаалаар санхүү аж ахуйн албаны дарга болон ерөнхий нягтлан бодогчийн албыг түр орлон гүйцэтгэгчээр тус тус томилсон байна. Мөн 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/142 тоот тушаалаар Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар болж оноосон нэр өөрчлөгдсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар нь 2021 онд нийт 4,089,671.8 мянган төгрөгийн 135 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 128,186.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх ажлын гэрээ 2021 оны 12 дугаар сарын 27-нд батлагдсан тул завсрын аудит хийгдээгүй.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь түүвэрт хамрагдаж шилэн дансны цахим хуудсанд 120.3 сая төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан байна. Холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн захирагчийн дараагийн аудитаар анхаарал татсан дараах асуудлуудыг авч үзэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Буянт ухаагаас Хөшгийн хөндий рүү хийсэн нүүлгэлт, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бэлтгэсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл тайлагнал;
2. Бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажиллаагүй, батлагдсан орон тооноос 27 албан хаагч илүү ажиллуулж 171,455.3 мянган төгрөгийн зардал гаргасан, шаардлагатай орон тоог дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,004.4 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 915.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 33,088.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 34,004.4 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 63,619.3 мянган төгрөгөөс 39,614.9 мянган төгрөгөөр бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Төлбөрийн акт

Цалинтай чөлөө авсан 3 албан хаагчид 915.6 мянган төгрөг нэмэгдэл олгож төсвийг үргүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга гэсэн батламж мэдэглийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ийг мөрдөж ажиллаагүй, төсвийг үргүй зарцуулсан тул төлбөрийн акт тогтоох

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Цалингийн зардалтай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:**

Тэтгэвэрт гарсан 1 ажилтныг гэрээгээр үргэлжлүүлэн ажиллуулж цалин хөлс 6,600.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; заалтуудыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:**

Шаардлагатай орон тоог дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах;

2. **Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

2.1. **Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 14 нэр төрлийн 16,548.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 9,940.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.30 үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн ангилал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг залруулах бичилт хийж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
							тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																	
1	ЧХОУНБГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТХН	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 14 нэр төрлийн тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн тавилга эд хогшлыг бүртгэсэн байна.	Бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх	1	26,488.8									1	26,488.8	
2	ЧХОУНБГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТХН	Тэтгэвэрт гарсан 1 ажилтныг гэрээгээр үргэлжлүүлэн ажиллуулж цалин хөлс олгосон.	Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах	1	6,600.0									1	6,600.0	
3	ЧХОУНБГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТХН	Цалинтай чөлөө авсан 3 албан хаагчдад нэмэгдэл олгосон	Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	915.6			1	915.6							
Дүн					3	34,004.4			1	915.6					2	33,088.8	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																	
1	ЧХОУНБГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТХН	Тайлант хугацаанд байршуулбал зохих 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх	1	128,186.0								1	128,186.0		
Дүн					1	128,186.0											
Нийт дүн					4	162,190.4			1	915.6				1	128,186.0	2	33,088.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 22/А/0150053
АХГ - 2022/188/НА - СТА - ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар нь цалинтай чөлөө авсан 3 албан хаагчид 915,600.00 төгрөгийн нэмэгдэл олгож, төсвийг үргүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заастай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалинтай чөлөө авсан албан хаагчдад илүү олгосон нэмэгдэл 915,600.00 /есөн зуун арван таван мянга зургаан зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын дарга Г.Баасандорж, ерөнхий нягтлан бодогч Б.Сувдаа нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.ДАШХОРЛОО

9006109
9019120396

001090094



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 148/А.О.150053
АХГ - 2022/188/НА - СРБ - ТХН

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар нь 2021 онд нийт 4,089,671,800.0 төгрөгийн 135 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 128,186,000.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргасан, өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2. "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэснийг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргасан тул хариуцсан нягтлан бодогч Б.Сувдаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын дарга Г.Баасандоржид даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Д.ДАШХОРЛОО

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
901912098
\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-131.Docx

0010800343

